Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Тухайлбал:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 07 сарын 09 -ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон.
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дүгээр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар “Засгийн газрын агентлагийн бүтэц орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2024 оны 12 сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон, 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богд хааны ордон музейн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Соёлын сайдын 2022 оны 01 сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан соёлын салбарын төсөвт байгууллагуудад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Богд хааны ордон музейн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 181,564.2 мянган төгрөгөөр буюу 0.99 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	290,104.3	430,214.4	140,110.1
Урьдчилгаа	33,810.7	37,638.1	3,827.4
Бараа материал	463,082.9	557,232.1	94,149.2
Үндсэн хөрөнгө	17,531,433.1	17,474,910.6	(56,522.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>18,318,431.0</b>	<b>18,499,995.2</b>	<b>181,564.2</b>
Өр төлбөр	1,241.6	31,279.3	30,037.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	18,317,189.4	18,468,715.9	151,526.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>18,318,431.0</b>	<b>18,499,995.2</b>	<b>181,564.2</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 140,110.1 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсөвт төвлөрүүлсэн 386,217.9 мянган төгрөгийг сангийн сайдын 2025 оны 12-р сарын 30-ны 240 дугаар тушаалын 6.1-д заасны дагуу санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 557,232.1 мянган төгрөг болж 94,149.2 мянган төгрөгөөр өссөн нь зарж борлуулах зорилгоор ном бүтээл орлогод авсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,474,910.6 мянган төгрөг болж, 56,522.5 мянган төгрөгөөр буурсан нь 152,742.9 мянган төгрөгийн дахин үнэлгээний зөрүү, 70,700.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлын бууралтаас шалтгаалсан байна.
- Өр төлбөрийн үлдэгдэлд 31,279.3 мянган төгрөг болж, 30,037.7 мянган төгрөгөөр өссөн байна. Өр төлбөр дансанд НДШ-ийн өглөг 952.2 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын өглөг 7,219.2 мянган төгрөг, ашиглалтын зардлын өглөг 1,212.5 мянган төгрөг, интернэтийн хураамжийн өглөг 86.9 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 20,160.0 мянган төгрөг, хувь хүнд төлөх өглөг 1,637.9 мянган төгрөг тус тус бүртгэлтэй байна. Тус үүссэн өр төлбөр нь сангийн яамнаас зарцуулах эрх нээгээгүйтэй холбоотой үүсэн байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 18,468,715.9 мянган төгрөг болж, 151,526.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

Богд хааны ордон музей нь 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 121 дугаар гэрээний дагуу Хас эрин орчил ХХК-ийн патент бүхий Динамик 1.0 нягтлан бодох бүртгэлийн программыг ашигладаг. Нийт ажил үйлчилгээ болон программын нэвтрүүлэлтийн төлбөр жилийн 440.0 мянган төгрөг бөгөөд энэ үнэнд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой шинэчлэлт, сайжруулалтыг цаг алдалгүй хийдэг байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,065,595.8 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 203,982.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,269,578.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 526,214.1 мянган төгрөгөөр бууруулж 743,364.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь байгууллага өөрийн үндсэн үйл ажиллагааны орлоготой тул цалин, ашиглалтын зардал, харуул хамгаалалтын зардлыг 50 хувиар бууруулан баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 83,837.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 827,201.0 мянган төгрөг болгож тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр 43 арга хэмжээг санхүүжүүлэхээр 827,201.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 442,377.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 742,249.1 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 761,539.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 709,248.0 мянган төгрөг буюу 85.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 117,953.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 691,145.9 мянган төгрөгийг зарцуулж, 18,172.1 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	71706	Соёлын өв	827,201.0	709,248.0	117,953.0	85.7
1.1	80801	Үндсэн үйл ажиллагааны зардал	648,760.3	640,142.3	8,618.0	98.7
1.2	80219	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	922.1	921.2	0.9	99.9
1.3	80215	Харуул хамгаалалтын зардал	47,889.8	47,889.8	-	100.0
1.4	81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	128,628.8	19,294.7	109,334.1	15.0
1.5	81908	Түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	1,000.0	1,000.0	-	100.0

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

**Бүтэц орон тоо:** Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээний хүрээнд 2025 оны 9 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон тооцооны нягтлан бодогч 1, үзмэр хянагч 1, эрдэм шинжилгээний ажилтан 1, нийт 3 орон тоог цомхотгож ажилласан.

**Хоол, унааны хөнгөлөлт:** Богд хааны ордон музейн захирлын 2025 оны А/01 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар хоолны хөнгөлөлтийг өдрийн 15.0 мянган төгрөгөөр, унааны хөнгөлөлтийг өдрийн 1.0 мянган төгрөгөөр батлан, мөрдөж ажилласан. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд 71,658.0 мянган төгрөг батлагдсан, гүйцэтгэлээр 66,531.9 мянган төгрөгийг зарцуулсан.

**Албан томилолт:** Богд хааны ордон музей нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гадаад томилолт, арга хэмжээний зардалд 39,054.0 мянган төгрөгийн төсөв батлуулснаас гүйцэтгэлээр 26,459.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Богд хааны ордон музей нь тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагатай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн жилийн явцад дээд шатны төсвийн захирагчаас 10,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 761,539.7 мянган төгрөг, нийт 771,539.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс хангамж бараа, материалын зардалд 23,652.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 93,829.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 233,109.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 32,729.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 2,000.0 мянган төгрөг нийт 385,321.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 386,217.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Улсын төсөвт төвлөрүүлсэн 386,217.9 мянган төгрөгийг МУ Сангийн Сайдын 2025 оны 12-р сарын 30-ны өдрийн 240 дугаар тушаалын 6.1-д зааны дагуу санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Богд хааны ордон музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төлбөрийг урьдчилж төлсөн боловч бараагаа аваагүй байгаа талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл-Аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Отгонжаргал, аудитор Н.Ганданбаавар нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, захирал Д.Товуудорж нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Цэлмэгбаяр, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Богд хааны ордон музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн 1,691,888.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 16,918.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь суудлын автомашин ашигладаггүй, суурин утасны төлбөрөөс өөр төрлийн утасны зардал гаргаагүй, байгууллагын ашиглалтын зардал, тог, цахилгааны усны "зөв хэрэглээ хэмнэлттэй зарцуулалт" аян зохион байгуулж тодорхой түшинд зөв хандлага бий болгож ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2,212,160.5 мянган төгрөгийн зөрчлөөс 2,212,160.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих зарлагын 6,267.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, 3-н мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж байх аудитын зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Илрүүлэлт 1. Богд хааны ордон музейн хойд талд байршилтай 9406м<sup>2</sup> талбай бүхий эзэмшил газар маргаантай байсныг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 001/ХТ2024/0105 дугаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхийн тогтоолоор Богд хааны ордон музейн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн ба одоо болтол газрын гэрчилгээ аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1. "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагад газрын гэрчилгээ гаргуулах хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2. Санхүүгийн тайланд Засгийн газрын хувь оролцоо дүрмийн санд 4,686,944.6 мянган төгрөг, Улсын бүртгэлийн гэрчилгээнд 2,481,051.6 мянган төгрөгөөр тусгасан бөгөөд 2,205,893.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл; 5.1. "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална. 5.1.4. үнэн зөв байх", 18.1. "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагад улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах хүсэлт хүргүүлж, шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, шилэн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 31,095.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 950.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 27,315.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 27,813.4 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснийг үнэлэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	950.4	3	950.4	100
Албан шаардлага	2	27,315.9	2	27,315.9	100
Зөвлөмж	4	27,813.4	4	27,813.4	100
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>56,079.7</b>	<b>9</b>	<b>56,079.7</b>	<b>100</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал ажиглагдсангүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 214,954.4 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрсэнд аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Соёлын өвийн бүртгэлийн дэд систем болон санхүүгийн тайлангаарх түүх соёл, музейн дурсгалт зүйлсэд бүртгэлтэй үзмэрийн дэсийн тоо хоёроор, үнийн дүн 214,954.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Эдгээр нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 23. "Санхүүгийн тайлан нь тухайн тайлангийн өдрөөрх уг байгууллагын нөөц ба үүрэг, түүнчлэн тайлангийн өдрүүдийн хооронд гарсан нөөцийн хөдөлгөөний талаарх мэдээллээр хэрэглэгчдийг хангадаг.....", санхүүгийн тайлагналын үнэлгээ, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 8,830.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 400.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8,430.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 8,830.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 8,088.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Гадаад томилолттой байх хугацааны хоол, унааны мөнгө нийт 400.0 мянган төгрөгийг 3 ажилтанд давхардуулан олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах, 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: “2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал” гэж тус тус заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Ажилтанд давхардуулан олгосон хоол, унааны мөнгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Урьдчилж төлсөн зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2024 онд Ай ти пи солюшн ХХК-д камер авахаар 8,430.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч одоо болтол бараагаа аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний дагуу нийлүүлэх бараа материалыг хүлээн авч зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ний дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Соёлын өвийн бүртгэлийн дэд систем болон санхүүгийн тайлангаарх түүх соёл, музейн дурсгалт зүйлсэд бүртгэлтэй үзмэрийн дэсийн тоо, үнийн дүн зөрүүтэй байна.	1	214,954.4	1	214,954.4			1	214,954.4				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>214,954.4</b>	<b>1</b>	<b>214,954.4</b>			<b>1</b>	<b>214,954.4</b>				

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Гадаад томилолттой байх хугацааны хоол, унааны мөнгө нийт 400.0 мянган төгрөгийг 2 ажилтанд давхардуулан олгосон.	1	400.0	1	400.0								
2	2024 онд Ай ти пи солюшн ХХК-д камер авахаар 8,430.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч одоо болтол бараагаа аваагүй байна.	1	8,430.0					1	8,430.0				
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>8,830.0</b>	<b>1</b>	<b>400.0</b>			<b>1</b>	<b>8,430.0</b>				

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих зарлагын 6,267.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, 3-н мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	1	6,267.5			1	6,267.5
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>6,267.5</b>			<b>1</b>	<b>6,267.5</b>
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Богд хааны ордон музейн хойд талд байршилтай 9406м2 талбай бүхий эзэмшил газар маргаантай байсныг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 001/ХТ2024/0105 дугаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхийн тогтоолоор Богд хааны ордон музейн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн ба одоо болтол газрын гэрчилгээ аваагүй байна.	1				1	
2	Санхүүгийн тайланд Засгийн газрын хувь оролцоо дүрмийн санд 4,686,944.6 мянган төгрөг, Улсын бүртгэлийн гэрчилгээнд 2,481,051.6 мянган төгрөгөөр тусгасан бөгөөд 2,205,893.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	2,205,893.0			1	2,205,893.0
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,205,893.0</b>			<b>2</b>	<b>2,205,893.0</b>
	<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>2,212,160.5</b>			<b>3</b>	<b>2,212,160.5</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 113/АДИСО122

Улаанбаатар хот

САГ - 2026/38/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Богд хааны ордон музейн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад томилолттой байх хугацаанд хоол, унааны мөнгө нийт 400,000.00 (дөрвөн зуун мянга) төгрөгийг 3 ажилтанд давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах," Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: "2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.5-д бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Гадаад томилолттой байх хугацаанд хоол, унааны мөнгө нийт 400,000.00 (дөрвөн зуун мянга) төгрөгийг давхардуулан тооцож олгосон буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Богд хааны ордон музейн захирлын үүрэг гүйцэтгэгч (Ц.Эрдэнэбаатар), нягтлан бодогч (Г.Пүрэвсүрэн) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-261230

Z:\Акт\2026\0225\САГ-53.Docx

1526163558